

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДОТООД АУДИТОРЫН 2025 ОНЫ ЗОРИЛГУУД, ТЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд Хорооны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Дотоод аудитор нь 2 зорилгын хүрээнд 5 ажил хийхээр төлөвлөж ажилласан болно.

№	Зорилго	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт, (зорилтод түвшин)	Биелэлтийн байдал	Хувь
СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ОНОВЧТОЙ ЗОХИЦУУЛАЛТ					
1.3. Холбогдох талуудад нээлттэй байнгын харилцааг бий болгоно.					
1.3.1	Хорооны үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах	1. Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлүүдэд зохицуулалтын үйл ажиллагааны эрсдэлийг эрт илрүүлэх, түүнийг бууруулах, хэрхэн зайлсхийх талаарх сургалтыг зохион байгуулах, зөвлөмжөөр ханган ажиллах;	Зөвлөлүүдийн хамрагдсан хувь 100%	2025 оны 10 дугаар сард Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүдэд зориулсан сургалтад Эрсдэлийн удирдлагын бодлого, түүнийг хэрэгжүүлэх заавар, үнэлэх аргачлалын талаар илтгэл бэлдэж танилцуулсан. Уг илтгэлээр сургалтад хамрагдсан ажилчид 1. Эрсдэлийн удирдлагын зорилго 2. Эрсдэлийн удирдлагын үйл явц 3. Эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах 4. Хяналт шинжилгээ хийх гэсэн 4 чиглэлээр зохих мэдлэг, заавар зөвлөгөөгөөр хангагдсан.	100%
		2. Хорооны нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэн дүгнэх, эрсдэлийн үнэлгээг хийсэн арга зүй болон хэрэгжүүлэлтийн байдалд хяналт тавьж хамтран ажиллах;	Эрсдэлийн түвшинг 13 нэгжид хүргэж бууруулах	Хорооны нэгжүүдэд “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ыг хүргүүлсэн. Одоогоор нэгжүүд тус тусынхаа эрсдэлийн үнэлгээг аргачлалын дагуу хийж байгаа бөгөөд 2026 оны 3 дугаар улиралд нэгтгэж хянахаар төлөвлөн ажиллаж байна.	70%
		3. Хорооны нэгжүүдийн үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхолын эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ хийх, зөвлөмжөөр хангаж ажиллах;	Авлига, ашиг сонирхолын зөрчил гарахгүй байх тогтолцоог	Хорооны санхүүгийн худалдан авалт хариуцсан ажилтаны худалдан авалтын байдлыг түүвэрчилсэн байдлаар хянаж, газар дээр нь тулган баталгаажуулах байдлаар ажиллаж холбогдох зөвлөмжийг өгч ажиллалаа.	100%

			бүрдүүлсэн байна.		
СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ					
3.1. Мэргэшсэн, чадварлаг, сэтгэл ханамжтай, бүтээлч хамт олныг бий болгоно.					
3.1.1	Дотоод аудит болон дотоод хяналтын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах.	1. Олон улсын зохицуулах байгууллагуудын дотоод аудитын сайн туршлагаас суралцах, түүнийг нэвтрүүлэх замаар дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулах.	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Төрийн хэмнэлтийн хуультай холбоотойгоор гадаад томилолтын зардал Хорооны төсөвт тусгагдаагүйгээс Олон улсын сайн туршлагатай газар дээр нь танилцаж суралцах боломж олгогдоогүй. Харин Монгол улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.5.2-т заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор тус тус баталж, хэрэгжүүлэх талаар ЗГ-ын салбар харьяа байгууллагуудад ирүүлсэн. Эдгээр баримт бичгүүдийг сайтар судалж, цаашид үр дүнтэй ашиглах замаар дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахаар ажиллаж байна.	95%
		2. Үндэсний аудит болон холбогдох дээд байгууллагаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулахад холбогдох нэгжүүдтэй хамтарч ажиллах, хяналт тавих.	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Үндэсний аудитын газраас жил бүр Хорооны санхүүгийн тайланд аудит хийдэг бөгөөд уг аудитаар Хороонд ирүүлсэн 2 зөвлөмж, 1 албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Уг 2 зөвлөмжийн биелэлтийг ЗУГ-аас цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан. Харин өмнөх оноос шилжиж ирсэн болон шинээр үүссэн нийт 217,374.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлийг 30%-иас багагүй түвшинд бууруулж ажиллах гэсэн шаардлагын биелэлт 87.4 хувьтай байна.	95%

ДҮГНЭЛТ:

Дотоод аудитор нь 2025 онд Хорооны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2 зорилго тавьж ажилласан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхээр 5 ажил төлөвлөж ажилласан байна. Эдгээр 5 төлөвлөсөн ажлын дундаж гүйцэтгэл 92.0 хувийн биелэлттэй байна.

Дотоод аудитор:

Ч.ЦООДОЛ